



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2019.07.30 № 2/1773
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Цагдаагийн сургууль, дамжаанд сонсогчоор суралцсан болон цагдаагийн байгууллагад туршилтын хугацаагаар дадлагажих ажилтнаар ажилласан хугацааг цагдаагийн алба хаасан хугацаанд оруулан тооцож цэргийн тэтгэвэр тогтоох талаар Цагдаагийн ерөнхий газраас өгсөн чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.2, 70.7 дугаар зүйлд тус тус заасны дагуу алба хаагчийн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн байгууллагын офицерын бүрэлдэхүүнд, Нийслэлийн цагдаагийн газрын (2012 оны 11 дүгээр сараас өмнөх хугацаанд дүүргийн Цагдаагийн хэлтсийн даргын), аймгийн Цагдаагийн хэлтсийн даргын тушаалаар ахлагчийн бүрэлдэхүүнд туршилтын хугацаагаар дадлагажих ажилтнаар ажилласан хугацааг төрийн тусгай албанд буюу цагдаагийн алба хаасан хугацаанд тооцох;

2. Мөн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллагын ахлагчийн бүрэлдэхүүнд ажиллах алба хаагчдад “цагдаа”, “цагдаагийн жолооч”, “дотоодын цэргийн харуулчин” мэргэжил эзэмшүүлэхээр цагдаагийн сургууль, дамжаанд сонсогчоор суралцуулсан хугацааг цагдаагийн алба хаасан хугацаанд тус тус оруулан тооцож Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоож олгоно.

Иймд энэхүү чиглэлд дурдсан Цагдаагийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, байцаагч, ажилтнуудыг мэдээлэл, арга зүйгээр хангаж ажиллахыг мэдэгдэж байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” 2/356 тоот албан бичгийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

ДЭД ДАРГА



Т.БАТМӨНХ

My doc.BHSG.SU A-4 /19.07-r sar/

1001162



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДЭД ДАРГА Г.САРАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18. Утас: 7019-1087. Факс: 7019-1087.
Web: www.police.gov.mn. E-mail: info@police.gov.mn

2019. 04. 25. № 2/356

танай _____-ны № _____-Т

Ажлын чиглэл хүргүүлэх тухай

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу албанаас чөлөөлөгдсөн цагдаагийн ахмад ажилтнуудаас харьяа нутаг дэвсгэрийн нийгмийн даатгалын нэгжид тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргахад "...Цагдаагийн мэргэжил эзэмшүүлэхээр сонсогчоор суралцсан, туршилтын хугацаагаар дадлагажих ажилтнаар ажилласан хугацааг төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцохгүй байгаа" талаар өргөдөл, гомдол ирүүлэх боллоо.


Цагдаагийн албаны тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт "Цагдаагийн албанд анх томилогдох иргэнийг албаны бэлтгэл, албан тушаалд тавигдах шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор 1 жил хүртэл туршилтын хугацаанд ажиллуулж болно", 70.2 дахь хэсэгт "Туршилтын хугацаагаар ажиллах иргэнийг дадлагажих ажилтнаар томилж гэрээ байгуулна. Дадлагажих ажилтан туршилтын хугацаанд гүйцэтгэх чиг үүрэгт нийцсэн энэ хуульд заасан эрх хэмжээг хэрэгжүүлж, үүрэг хүлээнэ", 70.7 дахь хэсэгт "Туршилтын хугацааг төрийн тусгай албанд ажилласан хугацаанд оруулан тооцно" гэж заасан.

Мөн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт "Цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан, ... цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан болон хуульд заасан бусад хугацааг цагдаагийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцно", Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь хэсэгт "... цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч"-нь цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг авах эрхтэй гэж тус тус заасан.

Цагдаагийн байгууллагаас дээрх эрх зүйн зохицуулалтыг үндэслэн офицерын албан тушаалд ажиллах дээд боловсролын, ахлагчийн албан тушаалд ажиллах "цагдаа", "цагдаа жолооч", "дотоодын цэргийн харуулчин" мэргэжил эзэмшүүлэхээр цагдаагийн сургууль, дамжаанд сонсогчоор суралцсан болон туршилтын болон дадлагажих ажилтнаар ажилласныг төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцож байгаа тул хуулийг нэг мөр, нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлэх шаардлага үүсч байна.

Иймд харьяалах нэгж, ажилтнуудад дээрх хуулийн зохицуулалтыг харгалзан үзэж, асуудлыг шийдвэрлэж байх талаар чиглэл өгч, хамтран ажиллахыг хүсье.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



РОТГОНЖАРГАЛ